



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар A/173

Өмнөдэлгэр сум

**Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан Үүсүүгийн Батбаатарын газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурдсанаар шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан байгууллагатай гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан Дуламын Баасанжавд үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн A/118 дугаар захирамжийн Үүсүүгийн Батбаатарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



Р.ЭНХТӨР



Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг
шилжүүлсэн болон шилжүүлэн авсан иргэний жагсаалт

Шилжүүлэн авч буй ААН, иргэний нэр	Регистрийн дугаар	Газрын хэмжээ /га/	Хугацаа /жил/	Газрын байршил	Зориулалт	Нэгж талбарын дугаар	Шилжүүлсэн ААН, иргэний нэр	Шилжүүлсэн үндэслэл
Дулам Баасанжав	СЭ63081916	1.0	8	5-р баг, Өртөө толгой	Өвөлжөө	2314002717	Үүсүү Батбаатар	Өөрийн хүсэлтээр
Дүн		1.0						